

Баянтал сумын 06-р сарын мэдээ

2024.06.21

Удирдлага зохион байгуулалт:

1. Архивын өрөөг шинэчилэн засварлах ажил хийгдэж байна.
2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлж бус 19 дүгээр хуралдаан 2024 оны 06 сарын 06-ны өдөр 5 суудлыг хэлэлцэж батлав.
2024 оны 06-р сарын 06-ны өдөр сумын Засаг даргын зөвлөлийн 7 дугаар хуралд 4 асуудлыг хэлэлцэж батлав.
Сумын баяр наадам зохион байгуулах ажлын хэсэг хуралдаж бэлтгэл ажлын явцтай танилцлаа.



3. Говьсүмбэр аймгийн орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгийн хээрийн дадлага сургалтад:
1,2 дугаар багийн засаг даргаар ахлуулсан 11 иргэн 4 хоног оролцлоо.
Үүнд:
төрийн албан хаагч -10
малчин иргэн -1
4. Сумын 2024 оны малын тоо толгойн хагас жилийн тооллого хийгдсэн. малын хагас жилийн тооллогоор 9 малчин, мал бүхий өрхийг хугацаанд нь тоолж программд оруулж шивж дуусгасан.



5. Баянтал сумын эмэгтэйчүүдийн холбооноос “Дулаахан говийн бүсгүйчүүд” арга хэмжээг 2024 оны 05-р сарын 31-ны өдөр зохион байгуулав.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах баярын өдрийг сумын хэмжээнд зохион байгууллаа. Тус үйл ажиллагааны нээлтэд давхардсан тоогоор 20 хүүхэд урлагийн номер үзүүлсэн байна. мөн 250 хүүхэд бэлэг өгч баярлуулж, 3x3 сагсан бөмбөг, унадаг дугуй уралдаан, оpen mic зэрэг уралдаан, тэмцээнийг зохион байгуулж хүүхэд багачуудыг баярлуулсан.



Сумын ЗДТГ-ны даргын тушаалаар 2024 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогууд хийгдэж байна.



2. Төсөв, санхүү- Шилэн данс

2024 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар 75,860.0 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 136,524.7 мянган төгрөг буюу 179.9 хувиар орлогыг давуулан биелүүлсэн байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 5,524.5 мянган төгрөг , авлага 3,576.8 мянган төгрөг байна. Үүнд: Тайлант онд ЕБС-ийн түлш халаалтын зардалд 1,860.8 мянган төгрөг, ЗДТГ-ын багийн томилолтын зардалд 770.0 мянган төгрөгийн өглөг, урьд оны НДШ-ийн өглөг 2,893.7 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Баянтал сумын ЗДТГ, ИТХ, ОНХСан, 4-р цэцэрлэг, ЕБСсургууль Шилэн дансны 2024 онд нийт мэдээлэх-2215, хугацаандаа мэдээлсэн-519 хугацаа хоцорсон-3, хугацаа нь болоогүй-1693 байгаа нь шилэн дансны мэдээ оруулалтын хувь 98.8 хувьтай байна

ТӨЛӨВЛӨЛТ:

Сумын ИТХ-ын 2024 оны оны 04-р сарын 30-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор тодотгол хийж 31 арга хэмжээ хийж гүйцэтгэхээр батлуулсан. Үүнд:

Нээлттэй тендер шалгаруулалт-1

Харьцуулалт-6

Он дамжсан-8

Шууд худалдан-8

Төсөл арга хэмжээ-3

МТТАТ-6

Нийт батлагдсан төсөв-1,116,397.2 төгрөг.

Эхний хагас жилд ХА-3, ШХА-5, МТТАТ-3 нийт 14 арга хэмжээг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН:

Цахим тендер-6, /НТШ, ХА/

2024 оны 06-р сарын 20-ны өдрийн байдлаар 100 хувь зарласан. Үүнээс амжилттай болсон 3. / 154-р байрны дээврийн засвар, Талын илчийн 150кв дизель цахилгаан үүсгэвэр тоног төхөөрөмж, Соёлын төвийн Лед дэлгэц./ **бүрэн хийж хүлээн авсан/** Худаг шинээр гаргах ажлын гүйцэтгэл-80 хувьтай явагдаж байна.

Нээлт хийх хугацаа болоогүй 3: /Ёс заншлын өргөө, Спорт заалны барилга, ЕБС-ийн Мэдээлэл зүйн танхимын тоног төхөөрөмж

ХҮРСЭН ТҮВШИН:

Цахим тендер зарлалт-100 хувь

Гэрээ байгуулсан-4

Нээлт хийх хугацаа болоогүй-3

Суманд Улсын төсвийн 4,67 тэрбум төгрөгөөр 3,4 км хатуу хучилтай авто зам тавих ажил хийгдэж байна. 2024 онд 1,8 км замын 2,33 төгрөгийн санхүүжүүлэлтэй ажил бүрэн хийгдээд ашиглалтад орсон. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудад сумын ИТХ болон иргэдийн хөндлөнгийн хяналтыг 2 удаа хийсэн. иргэдэд явцын талаарх мэдээллийг цаг тухай бүр хүргэж ажилласан

3. Статистик:

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн А/35 дугаар захирамжаар ХАА2, ХАА3 маягтуудын мэдээллийг оны эхэнд Сумын багийн Засаг дарга нар гаргаж, сумын санхүү албаны мэргэжилтнүүд medee.app.nso.mn программ шивж байна. Өвөлжилтийн хүндэрсэнтэй холбоотойгоор 2024 оны 06 дугаар сарын

05-ны байдлаар малын хорогдлын мэдээгээр үхэр- 1172 ширхэг, Адуу-1479 ширхэг, Хонь-12884 ширхэг, Ямаа – 8280 ширхэг нийт 23815 мал хорогдсон байна. Сумын засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/71 дүгээр захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй хагас жилийн түүвэрчилсэн тооллого эхлээд явагдаж байгаа бөгөөд Лүн баг 23 малчин болон мал бүхий өрх, Их уул баг 9 малчин болон мал бүхий өрх нийт 32 малчин болон мал бүхий өрх хамрагдаж байна.

4. Байгаль орчин:

Сумын 30 жилийн ойн хүрээнд 14, 16 дугаар зөрлөгийн хогийг цэвэрлэх мөн А0101 хатуу хучилттай автозамын дагуу хог цэвэрлэх ажлыг 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж ХХҮГ-тай хамтран Баянтал суманд гэрээгээр ажиллаж буй 6 хүн, Баянтал сумын ЗДТГ-ын 5 хүн нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй хог хаягдлыг цэвэрлэж 4 удаа хогны машинаар ачиж, нийт 10тн хог хаягдлыг хогийн цэгт ачиж, буулгасан байна.

16 дугаар, А0101 авто замын дагуу хогийг цэвэрлэхээс өмнө

16 дугаар, А0101 авто замын дагуу хогийг цэвэрлэсний дараа



Төсөв, санхүү- ХОРШОО

Сумын хэмжээнд 6 хоршоо бүртгэлтэй байна. Үүнээс “Шинэ хоршоо хөдөлгөөн” үйл ажиллагааны хүрээнд “МАЖӨТ малчид” хоршоо, “Ямбат талын есөн цацал” хоршоо, “Мушгиа зандангийн хэц” хоршоо шинээр байгуулагдсан.

“Боржигон хонгорын тал” хоршоо, “Цагаан айраг” хоршоо нь бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийн , цаашид үйл ажиллагаагаа идэвхжүүлэхээр бизнес төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

“Хөх ямаат шарилж” хоршоо, МАЖӨТ малчид”, “Оорцог-Элгэн” хоршоод нь бизнес төлөвлөгөө боловсруулан, хөрөнгө оруулалтын зээл авахаар ХААН банкаар судлуулж байна.

“Ямбат талын есөн цацал” хоршоо, “Мушгиа зандангийн хэц” хоршоо хөрөнгө оруулалтын зээл авахаар Төсөл боловсруулан , Төрийн банкаар судлуулахаар бэлэн болсон.

Сумын хэмжээнд 5 га газар эзэмшихээр хүсэлт гаргасан “Оорцог-Элгэн” хоршоо, “Хөх ямаат шарилж хоршоо”, “ Ямбат талын есөн цацал” хоршоодын хүсэлтийг сумын Засаг дарга хүлээн авч, Иргэдийн хурлаар хэлэлцүүлж дэмжсэн.

Нийгмийн салбарын хүрээнд:

- ▶ 2024 оны 06 дугаар сарын 03-13-ны өдрүүдэд 3,4,6,7,8-р ангийн анги дэвших 12 шалгалт, 5,9-р ангийн төгсөх 7 шалгалт зохион байгуулагдсан.
- ▶ 2024 оны 06-р сарын 17-18-ны өдрүүдэд төсвийн 3 байгууллагууд нийт 35 албан хаагч мод тарьж, усалгаа хийсэн
- ▶ Аймгийн Соёл урлагийн газраас томилогдсон ажлын хэсэг нь 6-р сарын 14-ний өдөр Соёлын төвд 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг хийлээ.
6-р сарын 14-ны өдөр аймгийн Соёл урлагийн байгууллагуудын албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх зорилгоор нөхөрлөл арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд хүрий ногоо –гарден гэсэн маршрутаар 19 км газар алхан АХА, хөгжөөнт уралдаант тэмцээнүүдэд идэвхтэй оролцлоо.
 - ▶ Зуны гэр цэцэрлэгт хүмүүжиж байгаа сумын 12 хүүхэд багачуудад 6-р сарын 18-ны өдөр явуулын үйлчилгээ үзүүллээ. Пороро үлгэрийн баатартай тоглож, үлгэр уншиж, 3dvrbox-оор музей үзэж хүүхдүүд нэг өдрийг сонирхолтой өнгөрүүллээ.
- ▶ **Амбулаторын үзлэг- 63**
- ▶ **Яаралтай тусламж- 27**
- ▶ **Идэвхтэй хяналт-2**
- ▶ **Өдрийн эмчилгээ-3**
- ▶ **Хэвтэн эмчлүүлсэн-14**
- ▶ **Гэрийн эргэлт -2**
- ▶ **Нярайн эргэлт- 1**
- ▶ **Товлолт дархлаажуулалт -12**
- ▶ **Алсын дуудлага Том хүн-2 хүүхэд-1**
- ▶ **Ойрын дуудлага-Том хүн-5 хүүхэд- 5**
- ▶ **Тэмбүү-0**
- ▶ **Дох-0**
- ▶ 6-59 сартай хүүхдүүд, нярайн хүүхэдтэй эхэд өндөр тунтай А аминдэмийг нийт 95 хүүхдэд уулгасан.
- ▶ 2 сараас, 2 настай хүүхдүүдэд товлотт вакциныг 12 хүүхдэд хийсэн.
Сэтгэцийн Эрүүл мэндийн төвөөс “Гамшгийн тухай ойлголт, гамшгийн үед илрэх сэтгэл зүйн хариу урвалууд, түүний үе шатууд, гамшгийг даван туулах чадвар” сэдвээр Эрүүл мэндийн албан хаагчид болон хэвтэн эмчлүүлж буй иргэдэд сургалт орсон.

БАЯНТАЛ СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР